



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1992 оны 3 дугаар
сарын 11 өдөр

Дугаар В.57

Улаанбаатар
хот

Нийслэлийн Боловсролын газрын
дүрэм батлах, ажилд томилох тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн Боловсролын газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн Боловсролын газрын даргаар Пүрэвдоржийн Доржийг 1997 оны 03 дугаар сарын 12-ноос томилж, сарын үндсэн цалинг 34950 төгрөгөөр, нэмэгдлийг үндсэн цалингийн 55 хувиар бодож тогтоосугай.

3. Албан хаагчдыг томилж, цалин нэмэгдлийг холбогдох журмын дагуу тогтоож ажиллахыг Нийслэлийн Боловсролын газар (н Дорж)-т даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 86 дугаар тогтоолын 16 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

[Handwritten signature]

Ж НАРАНЦАЦРАЛТ

85
Нийслэлийн Засаг даргын 1997 оны
8.37 дугаар захирамжийн хавсралт.

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газар нь (цаашид газар гэх) нийслэлийн нутаг дэвсгэрт боловсролын асуудлыг хариуцсан төрийн захиргааны орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллага мөн.

1.2. Газрын үндсэн зорилт нь нийслэлийн нутаг дэвсгэрт сургуулийн насны хүүхдийг бүх нийтээр хамран сургах, хүүхэд, залуучуудад шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх, тэднийг бүх талаар хөгжүүлэх, хүмүүжүүлэх, хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын түвшинг байнга дээшлүүлэх, сургалт хүмүүжлийн ажлын материаллаг баазыг бэхжүүлэхэд оршино.

1.3. Газар нь үйл ажиллагаандаа "Боловсролын тухай" Монгол улсын хууль бусад хууль, Гэгээрлийн сайдын тушаал, НИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.4. Газар нь нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газрын удирдлагын дор ажиллаж, ажлаа тайлагнана.

1.5. Газрын даргыг нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө. Боловсролын газрын бүтэц, зохион байгуулалт, орон тоог нийслэлийн Засаг дарга тогтоох ба батлагдсан орон тоонд багтаан боловсролын газрын дарга нь ажилтнуудаа томилж, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

1.6. Газар нь дэргэдээ Боловсрол төвтэй байх бөгөөд төвийн захирал, арга зүйчдийг газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.

1.7. Боловсрол төв нь нийслэлийн нутаг дэвсгэр дахь шинжлэх ухаан боловсролын бодлогын үндсийг боловсруулах, хэрэгжилтийг хянаж дүгнэх, ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажилд арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй бөгөөд Гэгээрлийн яамны баталсан дүрмийн дагуу ажлаа явуулна.

1.8. Газрын дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

1.9. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Нутаг дэвсгэртээ ерөнхий боловсрол олгох болон сургуулийн өмнөх насны хүүхдийн ба сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг удирдаж, сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамаруулах, сургуульд бэлтгэх, сургуулийн насны хүүхдэд суурь боловсрол олгох, тэдэнд ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэх, ёс суртахуун бие бялдар, гоо зүйн хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах,

2.2. Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд боловсролыг хөгжүүлэх бодлого чиглэлийг боловсруулахад оролцож батлагдсан төсөл, төлөвлөгөөг бүх үзүүлэлтээр нь биелүүлэх ажлыг зохион байгуулах.

2.3. Боловсролын багц хууль, Засгийн газрын тогтоол, Гэгээрлийн сайдын тушаал шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэнд нь хяналт тавих.

2.4. Нутаг дэвсгэртээ ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг зохистой байршуулж, тэдгээрийн үйл ажиллагаанд харъяалал харгалзахгүйгээр хяналт тавих.

2.5. Ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, сургууль үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаанд сургах, түгээмэл мэргэжил эзэмшүүлэх сурагчдын хөдөлмөр сургалтад төр захиргаа, аж ахуйн нэгж байгууллагын цөх, тэсгийг ашиглах ажлыг зохион байгуулах.

2.6. Ерөнхий боловсролын оройн ээлжийн болон эцнээ сургалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллаж байгаа зохих шатны боловсрол эзэмшээгүй залуучуудыг сургуульд бүрэн хамруулан суралцах бололцоогоор хангах.

2.7. Сургалтын лаборатори, кабинет, мастерын газрыг тогтоосон журмын дагуу байгуулах, хичээлийн хэрэглэл тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал, техник хэрэгсэл, сурах бичгийг захиалах, хуваарилах ажлыг зохион байгуулж, ашиглалтад нь хяналт тавих.

2.8. Нийслэлийн зарим дүүрэгт малчдын хүүхдийг дотуур байраар хангах зорилтыг бүрэн биелүүлэх, сурагчдын дотуур байрыг шаардлагын хэмжээнд хүртэл тохижуулах, сурагчдыг амт, чанар сайтай хоолоор хангах ажлыг зохион байгуулж хяналт тавих.

2.9. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрүүлжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуй, соёлын нөхцлийг сайжруулах арга хэмжээг Эрүүлийг хамгаалах болон холбогдох бусад байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх.

2.10. Хүүхэд залуучуудын чөлөөт цаг сурагчдын өвөл, зуны амралтыг зөв зохион байгуулж дотуур байрны сурагчдыг (Гачуурт, Жаргалант хорооны) уналгаар үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлтэнд хяналт тавьж, шаардагдах арга хэмжээ авах.

2.11. Сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг хөгжүүлж, нутаг дэсгэрийн нөөц бололцоог ашиглаж хүүхдийн цэцэрлэг (хувийн хэвшлийн сургууль цэцэрлэг) сургууль, хүмүүжлийн төв, тоглоомын талбай, хотхон уншлагын танхим, хөдөлмөр зуслан зэргийг байгуулах, барих ажлыг зохион байгуулах.

2.12. Ерөнхий боловсролын болон хүүхдийн цэцэрлэгийн асуудлаар үзэсгэлэн, хурал, семинар зөвлөлгөөн, болон биеийн тамир урлаг, спортын тэмцээн, уран бүтээлийн уралдаан, тойрон аялал төрөл бүрийн олимпиад зохион байгуулах.

2.13. Ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн бордны сургуулийн гадуур хүмүүжил олгох байгууллагыг боловсон хүчнээр хангах, багш сурган хүмүүжүүлэгчдийн мэргэшил онол, улс төрийн мэдлэг, сурган хүмүүжүүлэх ур чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, сахилга хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авч байх.

2.14. Боловсролын байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч байх.

2.15. Сурагчдын хичээл үйлдвэрлэлийн дадлагын үед хөдөлмөр хамгааллын дүрэм, зааврыг чанд мөрдүүлэх арга хэмжээ авч байх.

2.16. Өнчин болон асрах хүнгүй хүүхдэд асран хамгаалагч харгалзан дэмжигч томилуулах, эдгээр ясли, цэцэрлэг дотуур байртай сургуульд оруулах, асрамжийн газарт шилжүүлэх, хүүхдийг хараа хяналтгүй байлгах явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж шаардлагатай арга хэмжээ авч байх.

2.17. Нийслэлийн дүүрэг, хороодоос боловсролын салбарыг удирдах талаар зохиож байгаа ажилд хяналт тавьж зохих удирдлагаар хангах, боловсролын салбарыг хөгжүүлэх талаар дүүргээс зохиож байгаа ажилд хяналт тавьж, санал дүгнэлт өгөх.

2.18. Багш, сурган хүмүүжүүлэгчид, хөдөлмөрчдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авч, шаардлагатай мэдээ судалгааг холбогдох газарт гаргаж байх.

2.19. Хүн амын дунд сурган хүмүүжүүлэх мэдлэг дэлгэрүүлэх ажлыг хотын хэмжээнд системтэй зохион байгуулж, эцэг эх, тэднийг төлөөлөх хүмүүсээс үр хүүхдээ хүмүүжүүлэхэд нь сурган хүмүүжүүлэх туслалцаа үзүүлж байх.

2.20. Сургууль, цэцэрлэгт олгосон хөрөнгө оруулалтыг зөв зохистой хуваарилж барилга байгууламжийн их засварыг холбогдох газартай хамтарч шийдвэрлэх.

2.21. Шинээр байгуулагдаж байгаа сургуульд тусгай зөвшөөрөл гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх.

Гурав. Газрын эрх:

3.1. Боловсролын холбоотой асуудлаар дүүрэг, нутаг дэвсгэрийн, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын ажлыг шалгаж, тэдгээрийн удирдах ажилтан, мэргэжилтний илтгэл сонсголыг авч хэлэлцэх, үүрэг даалгавар өгч биелэлтийг нь хангуулах.

3.2. Боловсролын арга хэмжээнд хотын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих.

3.3. "Боловсролын сан"-г хот дүүрэгт зохих журмын дагуу байгуулах ажлыг зохион байгуулах, зарцуулалтыг дүүргийн холбогдох газарт шалган зааварлах.

3.4. Боловсролын асуудалтай холбогдолтой эмхтгэл, гарын авлага, зөвлөмж материалыг хэвлэн нийтлүүлэх.

3.5. Боловсролын газрын бүтэц зохион байгуулалтын талаар санал боловсруулж холбогдох байгууллагад тавих.

3.6. Боловсролын талаар төсөл хэрэгжүүлэх ажилд оролцох.

3.7. Ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилох асуудалд санал өгөх.